

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2018 оны 02 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар A/50, A/31

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2018 оны 03 сарын 06-ны
өдрийн 387 дугаарт бүртгэв.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хүлээн авах журам"-ыг 1 дүгээр, "...гэрээт талбайн эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын дүнг хүлээн авсан тухай баримт"-ыг 2 дугаар, "...гэрээт талбайн олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын дүнг хүлээн авсан тухай баримт"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-д, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-д, Аймаг, нийслэлийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Түлшний бодлогын газар /Ч.Чулуунбат/-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Уул уурхайн сайд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд нарын хамтарсан A/28-A/69 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Уул уурхай, хүндүйлдээр, Байгаль орчин,
аялатын жуулчлалын салдын хамтарсан
2018 оны 2 дугаар сарын 1-н өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ГАЗРЫН ТОС, УЛАМЖЛАЛТ БУС ГАЗРЫН ТОСНЫ ЭРЭЛ, ХАЙГУУЛ,
ОЛБОРЛОЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨРТСӨН БАЙГАЛЬ
ОРЧНЫГ НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫГ
ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн газарт байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг хүлээн авах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд /хуучнаар/-ын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлagnah журам"-ын 2 дугаар хавсралтын "Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга"-ын 2-т дурдсан "Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт"-тэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчны нөхөн сэргээлт нь Монгол Улсын Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага. MNS6200:2010 болон холбогдох бусад стандартуудын шаардлагыг хангасан байна.

2.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийг /цаашид гэрээлэгч гэх/ нөхөн сэргээлтийн ажлыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар бүхэлд нь эсхүл хэсэгчлэн гүйцэтгүүлж болно.

Гурав. Байгаль орчныг
нөхөн сэргээх ажлыг хүлээн авах

3.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үед 2 болон 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, өрөмдлөгийн үйл ажиллагааны үед эвдэрсэн газрын өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг Гэрээлэгч нь өөрийнх хүч, хөрөнгөөр хийж, хариуцлагыг хүлээнэ.

3.2. Олборлолтын үед өрөмдлөгийн шингэн хаягдлын сан, үйлдвэрлэлийн шингэний хаягдлын сан, тусгай зориулалттай шингэний хаягдлын сангийн болон тосоор бохирдсон хөрсний нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ.

3.3. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчны нөхөн сэргээлтийг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежмент болон хаалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгэнэ.

3.4. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүсэлтийг тухай бүр, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүсэлтийг тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараа Аймаг, нийслэлийн Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.

3.5. Энэхүү журмын 3.4-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар нөхөн сэргээлтийн ажлын үр дүнгийн биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах Ажлын хэсэг байгуулна.

3.6. Эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авах Ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон албан тушаалтан, байгаль орчны мэргэжилтэн, сум, дүүргийн иргэний төлөөлөл орно.

3.7. Олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг хүлээн авах Ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.

3.8. Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 30 хоногийн дотор газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг энэхүү журмын 2 дугаар хавсралт, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээсэн ажлын үр дүнг энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу тус тус баталгаажуулах ба үүгээр үр дүнг хүлээн авсанд тооцно.

Дөрөв. Бусад

4.1. Нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээн авахтай холбогдон гараг зардлыг гэрээлэгч бүрэн хариуцна.

4.2. Нөхөн сэргээлтийн ажлын үр дүнд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.

4.3. Газрын тосны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д заасны дагуу эскроу дансанд байршуулсан хөрөнгө гэрээлэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх баталгаа болно.

4.4. Нөхөн сэргээлтийг дахин гүйцэтгэхтэй холбогдон гараг зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

оооООооо

A/50, A/31

Уул-үүрхай, хүнд улдвэр, Байгаль орчин
аялаяа жуулчлалын сайдын хийтэарсан
2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



гэрээт талбайн эрэл, хайгуулын үйл ажиллагаанд өртсөн сайгаан орчныг
нөхөн сэргээх ажлыг хүлээн авсан тухай баримт

1. Холбогдох мэдээлэл

Эрлийн гэрээ байгуулсан этгээд /Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан гэрээлэгч:				
Гэрээт талбайн байршил:		Аймаг, нийслэл: Сум, дүүрэг: Баг, хороо:		
Нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэсэн хугацаа:				
Нөхөн сэргээлтийн үр дүнг хүлээлгэн өгсөн хугацаа:				
Тухайн жилийн эрэл, хайгуулын ажил		Нөхөн сэргээлтийн ажил		
Ажлын төрөл		Тоо хэмжээ /хэмжих нэгж/	Төлөвлөгөө /хэмжээ/	Гүйцэтгэл /хэмжээ/
2 хэмжээст чичирхийллийн судалгаа		Тэсэлгээ		
		Вибратор		
3 хэмжээст чичирхийллийн судалгаа		Тэсэлгээ		
		Вибратор		
Өрөмдлөг	Өрөмдлөгийн шингэний хаягдын сан	Техникийн		
		Биологийн		

2. Нөхөн сэргээлтийн чанар, үр дүн:

3. Цааш анхаарах ажлууд:

Эрлийн ажлын үед:

(сум, дүүрэг)-ийн Засаг дарга (эсхүл томилогдсон албан тушаалтан)

Хайгуулын ажлын үед:

(аймаг, нийслэл)-ийн Засаг даргын томилсон албан тушаалтан

(аймаг, нийслэл)-ийн БОАЖГ-ын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн

(аймаг, нийслэл)-ийн сум, дүүргийн иргэний төлөөлөл

Хүлээн зөвшөөрсөн:

Гэрээлэгчийн төлөөлөл

Нөхөн сэргээлт гүйцэтгэсэн компанийн төлөөлөл

